



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/178

Мандалговь

Ахмадад ээлтэй сум, байгууллага  
шалгаруулах тухай

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.3, Монгол улсын Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан журмын 239.2.3 дахь заалт, Аймгийн засаг даргын 2012 оны А/196 дугаар захирамжаар баталсан “Ахмадад ээлтэй сум, байгууллага” шалгаруулах журам, Засаг даргын зөвлөлийн 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 04 тоот хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. “Ахмадад ээлтэй сум”-ын шалгуур үзүүлэлтийг 93,3%-иар хангасан Өндөршил сумыг 2016 оны “Ахмадад ээлтэй сум”-аар шалгаруулж, батламж 500,000 /таван зуун/ мянган төгрөгөөр шагнасугай.

Хоёр. Ахмадад ээлтэй байгууллага”-ын шалгуур үзүүлэлтийг 91,2-93,7%-иар хангасан Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Сайнцагаан сумын Хүүхдийн 1-р цэцэрлэгийг 2016 оны “Ахмадад ээлтэй” байгууллагаар шалгаруулж тус бүрийг 200,000 /хоёр зуун/ мянган төгрөгөөр шагнасугай.

Гурав. Шагналд шаардагдах 900,000 /есөн зуун/ мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ



020000000